



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/83

Мандалговь

Г

Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

1

Төсвийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөрөнгөөр хийгдэхээр аймгийн ИТХ-ийн 2017 оны 04 дүгээр сарын 25 - ны өдрийн 15 дугаар тогтоолын 08 дугаар хавсралтын 2.1-д батлагдсан “Автомашины парк засвар /аймгийн Ахмадын хороо, Дэлгэрцогт/” -ын ажлын эрхийг Дэлгэрцогт сумын Засаг даргын тамгын газарт шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний шууд худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, холбогдох материалыг 2017 оны 07 сарын 01-ний дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Засаг дарга /Б.Иш-Ёндон/-д үүрэг болгосугай.

Гурав. Худалдан авах ажиллагааны бичиг баримтын бүрдлийг хянаж, журмын дагуу санхүүжилт олгохыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Санхүү төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА
О.ЧУЛУУНБАТ

0200190